



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургууль,  
цэцэрлэгүүдийн хэвийн үйл ажиллагааг  
хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 09 дүгээр сарын 16-аас 09 дүгээр сарын 19-ны өдрийг дуустал өдөр бүр 08:00 цагаас 18:00 цаг хүртэл 35/110 кв-ын Багахангай цахилгаан дамжуулах агаарын шугамд их засвар хийх тул Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг доголдуулахгүй хэвийн үргэлжлүүлэхийг сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт, цахилгааны нөөц үүсгүүрийн хэвийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-д тус тус үүрэг болгосугай.

2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай 895,200 (Найман зуун ерэн таван мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2024 он ажил/захирамж

110320049

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 09 сарын 16-ны өдрийн 1149 дугаар  
захирамжийн хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙН ХЭВИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг Бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	литр	240	3730	895,200
<b>Нийт дүн</b>					<b>895,200</b>